



## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2012 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 421

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

МУИС-ийн дүрмийн 2.1.5, 5.8.2 дахь заалт, МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2011 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “МУИС-ийн Оюуны өмчийн талаар баримтлах бодлого”-ыг 1 дүгээр хавсралтаар, “МУИС-ийн Технологи дамжуулах журам”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Шинээр батлагдсан бодлого, журмыг 2012 оны 9 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Батлагдсан бодлого, журмыг нийт багш, ажилчдад танилцуулж үйл ажиллагаандаа мөрдүүлэн, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал /Ч.Ганзориг/, Технологи дамжуулах төв /Д.Батхуяг/ нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Д-р, Проф. С.ТӨМӨР-ОЧИР

Захирлын 2012 оны 8 дугаар сарын 31-ны  
өдрийн ... тоот тушаалын 1 дүгээр хавсралт

## МУИС-ИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

### 1 дүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү бодлогын баримт бичгийн зорилго нь МУИС-ийн оюуны өмчийг бүтээх, хамгаалах, аж үйлдвэрт шилжүүлэх, слон нийтийн хүртээл болгоход баримтлах бодлогыг тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү бодлогын баримт бичигт хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.2.1. "Технологи" гэж шинэ бүтээл, ашигтай загвар, нээлт, компьютерийн програм, түүнчлэн төрөл бүрийн хэлбэрээр бичигдсэн мэдээлэл, бичмэл материалыг оруулан өргөн хүрээгээр ойлгоно. Мөн "технологи" гэсэн ойлголтод шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнд бий болж, эдийн засаг, нийгмийн үр ашиг авчрах шинэ болон шинэчлэн сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн шийдлийг илэрхийлэх инновацийг хамруулна.

1.2.2. "Судлаач" гэж МУИС-ийн дүрэмд заасан багш, ажилтныг хэлнэ.

1.2.3. "Зочин судлаач" гэж МУИС-ийн хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт гадны байгууллагаас хамрагдан оролцож байгаа этгээдийг хэлнэ.

1.2.4. "Суралцагч" гэж Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 15.1-д заасан этгээдийг, мөн докторын дараах сургалтанд хамрагдаж байгаа этгээдийг хэлнэ.

1.2.5. "МУИС-ийн нэгж" гэж МУИС-ийн дүрэмд заасан бүрэлдэхүүн сургууль, тэнхим, лаборатори, профессорын баг, МУИС-ийн бүрэлдэхүүн болон харьяаллын нэгжийг хэлнэ.

### 2 дугаар зүйл. Оюуны өмч

2.1. МУИС-ийн судлаач, суралцагч, зочин судлаач болон МУИС-ийн төсөл, хөтөлбөрүүдэд оролцож буй этгээдийн бүтээсэн, хөгжүүлсэн шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, маск загвар, судалгааны биет бүтээл болон компьютерийн програм хангамж, хэвлэмэл материал гэх мэт зохиогчийн эрхээр хамгаалагдах бүтээлийг эзэмших, захиран зарцуулах эрхийг дор дурьдсанаар эдлэнэ.

2.2. Зохиогч нь эзэмших оюуны өмч. Үүнд:

2.2.1. Тодорхой гэрээ, төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд бий болоогүй,

2.2.2. Албан үүргийн дагуу хийгээгүй бөгөөд МУИС-тай эзэмших эрхийг шилжүүлэх талаар бичгээр гэрээ байгуулаагүй,

2.2.3. МУИС-ийн санхүүжилт, өмч хөрөнгийг (facility) мэдэгдэхүйц хэмжээнд (significant use) ашиглан бүтээгдэгүй бүтээл.

2.3. Бусад тохиолдолд дараах байдаар шийдвэрлэнэ. Үүнд:

2.3.1. Тодорхой гэрээ, төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд бий болсон оюуны өмчийг гэрээнд заасны дагуу эзэмших, захиран зарцуулах эрхийг шийднэ.

2.3.2. Албан үүргийн дагуу бий болсон, эсвэл МУИС-ийн хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн санхүүжилт, өмч хөрөнгийг (facility) мэдэгдэхүйц хэмжээнд (significant use) ашиглан МУИС-ийн судлаач, суралцагч, зочин судлаач болон бусад этгээд бүтээсэн, хөгжүүлсэн оюуны өмчийг МУИС өмчилнэ.

### **3 дугаар зүйл. МУИС-ийн өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээнд ашиглаагүй гэж үзэх нөхцөл**

3.1. Дараах нөхцөлд МУИС-ийн өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээнд ашиглаагүй гэж үзнэ. Үүнд:

3.1.1. Бага хэмжээний хориглоогүй санхүүжилт ашигласан бол,

3.1.2. Судлаачийн судалгааны үндсэн чиглэл, эсвэл захиалгат судалгааны ажлын сэдвийн хүрээнд хамаарахгүй бүтээл бол,

3.1.3. Чухал ач холбогдолтой тоног төхөөрөмжийг маш бага хугацаанд ашигласныг холбогдох нэгжийн удирдлага тодорхойлсон, эсвэл зөвхөн ач холбогдол багатай хөрөнгө, тоног төхөөрөмж хэрэглэсэн бол,

3.1.4. Зохиогч бүтээлийг хувийн, ажлын бус цагт бүтээсэн бол МУИС-ийн өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээнд ашиглаагүй гэж үзнэ.

### **4 дугаар зүйл. Дипломын ажлын өмчлөл**

4.1. Оюутны дипломын ажлын зохиогчийн эрхийг дараах байдлаар шийдвэрлэнэ. Үүнд:

4.1.1. МУИС-аас цалин, хөлс, буцалтгүй тусламж хэлбэрээр санхүүжилт олгосон судалгаанд тулгуурлан хийсэн дипломын ажлын зохиогчийн эрхийг гэрээгээр шийдвэрлэнэ. Хэрэв гэрээнд зохиогчийн эрхийг тусгайлан заагаагүй бол МУИС эзэмшинэ.

4.1.2. МУИС-ийн тоног төхөөрөмж, өмч хөрөнгийг ашигласны улмаас зохиогчийн эрхийн хязгаарлалт хийсэн судалгааны ажлыг багтаасан дипломын ажлыг МУИС эзэмшинэ.

4.2. Дээрх хоёр нөхцөлд зааснаас бусад нөхцөлд оюутан дипломын ажлын зохиогчийн эрхийг эзэмшинэ. Харин МУИС тус дипломын ажлыг үнэ төлбөргүйгээр ашиглах, олшуулах, олон нийтэд түгээх эрхийг эдэлнэ.

4.3. МУИС-ийн өмчийг зохиогчийн эрхийн хязгаарлалтгүйгээр өгч ашиглуулсан бол дипломын ажлын зохиогчийн эрх тухайн оюутанд хадгалагдана.

### **5 дугаар зүйл. Захиалгат судалгаа ба бусад гэрээт ажлууд**

5.1. Засгийн Газрын захиалгат судалгааны ажлын явцад анх санаачлан гаргасан, эсвэл бодит нөхцөлд буулган бүтээсэн шинэ бүтээлийг эзэмших эрх бүхий субъектийг Засгийн Газартай байгуулсан гэрээгээр тодорхойлно. Засгийн Газрын захиалгат судалгааны ажлын явцад бүтээсэн оюуны өмчийг Засгийн Газар зохиогчийн эрхийн шимтгэл (royalty-free)-гүйгээр лиценз эзэмших эрхтэй.

5.2. МУИС-д эзэмших эрх нь хадгалагдаж байгаа оюуны өмчид, лиценз олгох болон бусад арга замаар шинэ бүтээлийг бодит хэрэглээнд үр дүнтэй нэвтрүүлэх үүргийг МУИС хүлээнэ.

5.3. Үйлдвэр, компаниудын захиалгат судалгааны ажлын хүрээнд бүтээсэн оюуны өмчийг, гэрээнд нарийвчлан заагаагүй бол МУИС эзэмших эрх эдлэх бөгөөд тухайн захиалагч байгууллага давуу эрхтэйгээр лицензээр эзэмшиж болно.

5.4. Байгууллагын захиалсан гэрээт судалгааны ажлын хүрээнд бүтээсэн бүтээлийг зохиогчид захиалагч талтай байгуулсан гэрээнд тусгайлан зохицуулаагүй нөхцөлд хэвлүүлэх, эсвэл түүнтэй төстэй хэлбэрээр нийтэд дэлгэрүүлэх эрхтэй.

### **6 дугаар зүйл. Албан үүргийн дагуу бүтээгдсэн бүтээл**

6.1.“Албан үүргийн дагуу бүтээсэн бүтээл” гэдэг нь орон тооны ажилтан албан үүргээ гүйцэтгэх буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад бүтээсэн, хөгжүүлсэн шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, маск загвар, судалгааны биет бүтээл болон компьютерийн програм хангамж, хэвлэмэл материал гэх мэт зохиогчийн эрхээр хамгаалагдах бүтээлийг хэлнэ.

6.2.Гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд, тухайн бүтээлийг ашиглах зохиогчийн эрх нь ажил олгогчид үлдэнэ.

6.3.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн дагуу бичмэл гэрээнд өөрөөр заагаагүй бол орон тооны бус буюу гэрээт ажилтаны гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүнг гүйцэтгэгч нь эзэмшинэ.

## 7 дугаар зүйл. Шинэ бүтээл ба үнэт мэдээллийн нууцын гэрээ

7.1.МУИС-д технологи эзэмших эрх эдлэх зарчим, дэг журмыг нийт ажилтан, захиалгат судалгааны төсөлд оролцогч, МУИС-ийн санхүүжилт ба өмч хөрөнгийг ашиглаж буй бүх этгээд хүлээн зөвшөөрч, дагаж биелүүлэх үүрэгтэй бөгөөд дор дурдсан бодлогын заалтуудыг зөвшөөрч, Шинэ бүтээл ба үнэт мэдээллийн нууцын гэрээнд гарын үсэг зурна. МУИС-ийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх баг, хувь хүн:

7.1.1.(а) захиалгат судалгаа эсвэл МУИС-ийн санхүүжүүлсэн төслөөс санхүүгийн дэмжлэг авсан,

7.1.2.(б) захиалгат эсвэл МУИС-аас санхүүжсэн судалгааны үр дүнд шинэ бүтээлийг бүтээсэн буюу хөгжүүлсэн, бодит хэрэглээнд нэвтрүүлсэн, технологийг хөгжүүлсэн,

7.1.3.(с) МУИС-ийн санхүүжилт, өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээгээр ашигласан этгээд цалин буюу бусад хэлбэрийн дэмжлэгийг авсан эсэхээс үл хамааран МУИС-ийн Шинэ бүтээл ба үнэт мэдээллийн нууцын гэрээнд гарын үсэг зурна. Энэ шаардлага нь зөвхөн МУИС-ийн судлаач, суралцагч төдийгүй бүх зочин судлаач болон бусад мэргэжилтнүүдэд хамаарна.

7.2.МУИС-ийн нэгж бүр захиалгат төсөлд оролцсон, эсвэл оролцох магадлалтай, эсвэл МУИС-ийн мэдэгдэхүйц өмч хөрөнгө, нөөцийг тухайн салбараар дамжуулан авч ашиглах боломжтой судлаач, суралцагч, зочин судлаач бүрийг Шинэ бүтээл ба үнэт мэдээллийн нууцын гэрээнд гарын үсэг зуруулах үүрэгтэй.

## 8 дугаар зүйл. Зөвлөх үйлчилгээний гэрээ

8.1.МУИС нь судлаач, суралцагчийн өмнөөс ямар нэг зөвлөх үйлчилгээний гэрээ хийхгүй.

8.2.МУИС-ийн судлаач, суралцагчид нь гуравдагч этгээдтэй зөвлөх үйлчилгээний гэрээг хийсэн тохиолдолд, МУИС-ийн өмнө хүлээсэн тэдний үүрэг хариуцлагатай зөрчилдөхгүй байх ёстой.

8.3.МУИС лицензийн зохицуулалтын талаар зөвлөх үйлчилгээний гэрээ хэлцэлийг бүтээгч буюу зохиогч хувь хүнтэй хийхгүй. Зөвхөн албан байгууллагатай зөвлөх үйлчилгээний гэрээ хийж болно.

## 9 дүгээр зүйл. Зохион байгуулалт

9.1.МУИС нь өөрийн оюуны өмчийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох эрх бүхий **Оюуны өмчийн хороотой** байна.

9.1.1.Оюуны өмчийн хорооны гишүүдийг МУИС-ийн Эрдмийн зөвлөлөөс томилно.

9.1.2.Гишүүдийн олонхийн саналаар хорооны даргаа сонгоно.

9.2 .МУИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал нь энэхүү бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан маргаан, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

9.3 .Зарим онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд Эрдэм шинжилгээ инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал энэ журмаар зохицуулагдахгүй шийдвэрийг МУИС-ийн Оюуны өмчийн хороотой зөвшилцсөний үндсэн дээр гаргаж болно.

9.4 .МУИС оюуны өмчийн бодлогын дагуу МУИС-ийн технологийг дамжуулах, түүний үр дүнд бий болсон хөрөнгө санхүүгийн эх үүсвэрээр сургалт, судалгааны ажлыг дэмжих чиг үүрэг бүхий **Технологи дамжуулах төвтэй** байна.

9.4.1.Технологи Дамжуулах Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг тус төвийн дотоод журмаар, МУИС-ийн технологийг үнэлж, оюуны өмчийн хамгаалалт хийж, технологийг судалгааны зорилгоор дэлгэрүүлэхэд туслалцаа үзүүлэх ба үйлдвэрлэлд нэвтрэх боломжтой технологийг сонгон авч, боломжит зах зээлийг нь тодорхойлж, лицензийн гэрээг байгуулах болон арилжих үйл ажиллагааг МУИС-ийн Технологи дамжуулах журмаар зохицуулна.

## **10 дугаар зүйл. Сургалтын материал**

10.1 . МУИС-ийн судлаач зохиогчийн эрхтэй бүтээл буюу сургалтын материал бүтээсэн тохиолдолд МУИС нь тухайн бүтээлийг хэзээ, хэрхэн яаж, ямар арга замаар түгээн дэлгэрүүлэх талаар зохиогчийн шийдвэрийг хүндэтгэж үзнэ. Сургалтын материалыг бүтээхэд МУИС-иас тодорхой санхүүжилт, дэмжлэг үзүүлсэн, эсвэл тодорхой нөхцөлтэй гэрээ байгуулсан тохиолдолд тухайн бүтээлийн зохиогчийн эрхийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу МУИС болон Зохиогч хамтран, эсвэл МУИС дангаараа эзэмшинэ.

10.2 . Мөн суралцагчийг хийсэн бүтээлийнхээ зохиогч нь буюу санаачлагч нь гэж үзнэ. Суралцагчийн бүтээсэн сургалтын материалыг ашиглах тохиолдолд суралцагч нь эд хөрөнгийн, эсвэл эд хөрөнгийн бус зохиогчийн эрх эдлэнэ.

## **11 дүгээр зүйл. Бусад**

11.1 .МУИС-ийн Оюуны өмчийн талаар баримтлах бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн, МУИС-ийн Оюуны өмчийн хороонд уламжилж, МУИС-ийн Эрдмийн зөвлөлөөр эцэслэн шийдвэрлүүлнэ.